



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

2024.01.26 № А-1/167
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ПНШНУГТЭ/202412001 дугаартай “П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэгт 2024 онд хэрэглэгдэх эм, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, протез худалдан авах” тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэлтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичгийн “... Тендерийн үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт” хэсэгт заагдсан үнэ 70 ба чанарын үнэлгээ 30 оноо гэсэн байх ба энэхүү аргачлал нь Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан Ерөнхий гэрээний аргаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн шалгаруулалтын жишиг баримт бичгээс үнэ 30 ба чанарын үнэлгээ 70 оноо, мөн шаардаж буй бичиг баримт нь зөрүүтэй байна. Ингэж хоёр өөр янзаар үнэлгээ хийж болох эсэх.

Тодруулгын хариу: Тус тендер шалгаруулалтыг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зарласан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос өмнө зарласан тендер шалгаруулалтыг 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж дуусгана” гэж заасны дагуу 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж байна.

2. Захиалагч үнэлгээний хороонд салбарын буюу мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцоог хангаж байгаа юу. Та бүхэн 2023 оны тендерийн үнэлгээний хороонд салбарын буюу мэргэжлийн төрийн бус байгууллагын нэг ч оролцуулаагүй, мэргэжлийн шинжээч, зөвлөх ажиллуулаагүй хууль, журмыг ноцтойгоор зөрчиж, тендерийг хүчээр, будлиантай зохион байгуулсан байна.

Тодруулгын хариу: Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёрдогч доошгүй

төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэж заасанд нийцүүлэн төрийн бус байгууллагын хоёр төлөөлөгч, П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмч, эм зүйч нарын төлөөлөл үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон.

3. Тендер шалгаруулалтын багц 85-т хүүхдийн оксигенатор 11-24 кг, хүүхдийн оксигенатор 25-40 кг, хүүхдийн оксигенатор 4-10 кг, оксигенатор /том хүний/ гэснийг бусад хэрэгслээс салгаж өрсөлдөх тэгш боломжоор хангаж өгнө үү.

4. Тендер шалгаруулалтын багц 86-т EOPA артерийн каннюль 10, 12, 14, 16Fr гэж зааж өгсөн байна. Дээрх размер нь хүүхдэд зориулсан байдаг ба нэршил нь DLP артерийн каннюль гэдэг. Иймд мэргэжилтэнгүүдээсээ тодруулан тодорхой болгож өгнө үү.

5. Тендер шалгаруулалтын багц 86-т гуяны артер болон венийн каннюлийг Сельдингер аргаар нэвтрүүлэх иж бүрдэл гэж зааж өгсөн байна. 2023 оноос эхлэн гуяны артерийн болон гүрээний венийн каннюль нь Сельдингертэй нэг цул иж бүрдэл болсон. Иймд мэргэжилтэнгүүдээсээ тодруулан тодорхой болгож өгнө үү.

6. Тендер шалгаруулалтын багц 94 чиглүүлэгч интродюсер гэснийг бусад хэрэгслээс салгаж өрсөлдөх тэгш боломжоор хангаж өгнө үү.

7. Тендер шалгаруулалтын багц 95 чиглүүлэгч интродюсер гэснийг бусад хэрэгслээс салгаж өрсөлдөх тэгш боломжоор хангаж өгнө үү.

8. Тендер шалгаруулалтын багц 105 тархины судасны нарийн диаметртэй бичил ороомог, био мэдрэгчтэй салгагчийн хамт гэснийг бусад хэрэгслээс салгаж өрсөлдөх тэгш боломжоор хангаж өгнө үү.

9. Тендер шалгаруулалтын багц 136 ангиогийн нэг удаагийн багц гэснийг бусад хэрэгслээс салгаж өрсөлдөх тэгш боломжоор хангаж өгнө үү.

Тодруулгын 3-9-т заасан хариу: Тодруулгын дагуу П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг 85, 86, 94, 95, 105 дугаар багцуудад өөрчлөлт оруулж тусад нь багц үүсгэх, тендер шалгаруулалтын 136 дугаар багцыг хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.5 дахь хэсэгт заасны дагуу багцалсан тухай тодруулгын хариуг тус газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/84 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Тус тендер шалгаруулалтын 85, 86, 94, 95, 105 дугаар багцуудыг үргэлжлүүлэн зохион байгуулахдаа тендерийн урилгын дугаар тусад нь үүсгэж байгаа тул тендерийн баталгааг дахин гаргана уу.

П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/84 дугаар албан бичгээр ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: *22* хуудастай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ